

МЭРГЭЖЛИЙН ТӨВШИНД АЖИЛЛАХ НЬ  
СЭТГҮҮЛЧИЙН УР ЧАДВАРЫН ҮНДЭС МӨН

Р. Оюунцэцэг\*

\* МХХ-ийн багш, МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн докторант.

**Түлхүүр үг:** сэтгүүл зүйн зарчмууд, сэтгүүлчийн мэргэжлийн төвшин, сэтгүүл зүйн чанар, сэтгүүлчийн ур чадварыг тодорхойлох үндсэн шалгуур.

“Сэтгүүл зүйн мэргэжлийн чанарт би итгэдэг” гэж 1908 онд байгуулагдсан дэлхийд анхных болох Миссурийн Сэтгүүл зүйн сургуулийг үндэслэгчдийн нэг, сэтгүүл зүйн анхны багш нарын нэг Уолтер Вильямс бичжээ. Мэргэжлийн чанар гэсэн ерөнхий ойлголтын цаана сэтгүүл зүйн хариуцлагыг тодорхойлох, сэтгүүлчийн ур чадварыг илтгэх, уншигчийг хүндэтгэх зэрэг бүхий л хэм хэмжүүрийн үндэс болсон сэтгүүл зүйн зарчмын асуудлуудыг тэрээр хамруулан тайлбарласан байдаг. “Тодорхой бодол санаа ба тодорхой мэдээлэл, нягт нямбай ба шударга байдал нь сайн сэтгүүл зүйн үндэс” хэмээсэн Вильямсын тодорхойлолт өнөөдөр Америкийн төдийгүй, Өрнө, Дорны хариуцлагатай сэтгүүл зүйд тууштай баримтлагддаг зарчмууд болон нэгэнт тогтжээ.

**Бодитой, баримттай байх** зарчим нь мэдээ мэдээллийг бичихдээ үзэл бодлоос илүүтэйгээр баримтыг чухалчилж үзэхийг хэлнэ. Мөн энэ нь нягт нямбай байдал,

алдаа мадаггүй, аливаа эргэлзээ төрүүлэхээргүй байх, баримтыг зөв аргаар олж авах, мөн түүнчлэн зөв баримт олохыг илэрхийлнэ.

**Үнэнч байх** зарчим нь хууран мэхлэх, залилан луйвардахгүй байхыг хэлэх ба баримтыг гажуудуулахыг хэзээ ч зөвшөөрөх ёсгүй бөгөөд гаргасан аливаа алдаа мэдгийг зайлшгүй залруулахыг хэлнэ

**Шударга байх** зарчим нь хувийн сонирхол, хөнгөмсөг, шударга бус, ташаа бодол ойлголт, тал тохой татах зэрэг байдлыг танин мэдэх, хянахыг хэлнэ. Сурвалжлах явцдаа тал тохой татах байдлыг хэзээ ч үл зөвшөөрнө.

**Бүрэн төгс байх** зарчим нь нөхцөл байдал, түүний учир холбогдол, тэнцвэрт байдал, хэтийн төлөв зэргийг хэл, өнгө аяс, туршлага, сэтгэл хөдлөл зэргийг ашиглан харуулахыг хэлнэ. Тэнцвэрт байдлыг хангана гэдэг нь ноёлж давамгайлсан санаа бодлыг илэрхийлэхийн сацуу бусад бүхий л зөрчилдөөнтэй, ялгаатай болон нэмэлт санаа бодлыг дурдах төдий бус байхыг хэлнэ.

Жинхэнэ мэргэжлийн төвшин, стандартыг хангах сэтгүүл зүйн эдгээр зарчмыг сэтгүүлчид өөрийн ажлын мөрдлөг болгосноор тухайн сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар

хэмжиндэж, хэвлэл мэдээллийн хэрэгснүүд эдгээрийг тууштай баримталснаар өнөөдөр өөрийн хэвлэлийн тогтвортой байдлыг бий болгоно гэж хэвлэл мэдээллийн судлаачид үздэг. Тэгснээр тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн редакци болон сэтгүүлч бие даасан байдлаа бататгаж, өөрсдийн уншигч, үзэгч, сонсогчийн итгэл үнэмшлийг хүлээх үндсэн шалгуур үзүүлэлт болдог байна.

Тэгвэл чөлөөт хэвлэлийн үндэс суурь тавигдаад арван таван жилийн нүүр үзэж байгаа Монголын сэтгүүл зүйн чанар чансаа

дээрх мэргэжлийн шалгууруудын илэрхийлэл байж чадаж байна уу? гэсэн асуудал мэргэжлийнхний хүрээнд төдийгүй, олон нийтийн дунд үе үе сөхөгддөг. Тэр бүрдээ хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хангалттай үнэлгээ авч байгаагүй. "Монголын хэвлэл мэдээлэл дөрөв дэх засаглалын үүргээ гүйцэтгэж чадахгүй байна, сэтгүүл зүй

эздийн халаасанд багтаж байна, сэтгүүлчид нь утсан хүүхэлдэйгээс ялгаарах зүйл алга", "хэвлэл мэдээлэл нийгмийг хагалан бутаргаж байна", "хүчтэй иргэний төлөөлөл байж чадахгүй байна" зэрэг ишлэл Монголын сэтгүүл зүйн одоо цагийн түгээмэл үнэлгээний жишиг болох юм. 2003 оны 3-р сард "Мэдээллийн тэнцвэрт байдлыг хангая" сэдвээр зохион байгуулсан онол-практикийн бага хуралд нийтлэлч Б.Баабар: "Монголын сэтгүүл зүй өнөөдөр бизнес чиглэлээр түлхүү хөгжиж, сонин хэвлэл зөвхөн хялбар мөнгө

олох арга хэрэгсэл болжээ. Хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд сэтгүүл зүйн зарчим нь дөрөв, тавдахь асуудал болж хувирсан, тиймээс Монголд эхлээд хувирсан, мэргэжлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрэгтэй байна" гэж хэлсэн нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Бүх хүн, улс орны хувьд нэгэн адил нээлттэй, олон ургальч, мэдлэг, мэдээллийг олж авах боломжийг Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр олгож чадахгүй байна. Гэтэл сэтгүүл

«  
*Жинхэнэ мэргэжлийн төвшин, стандартыг хангах сэтгүүл зүйн эдгээр зарчмыг сэтгүүлчид өөрийн ажлын мөрдлөг болгосноор тухайн сэтгүүлчийн мэргэжлийн ур чадвар хэмжигдээс, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эдгээрийг тууштай баримталснаар өнөөдөр өөрийн хэвлэлийн тогтвортой байдлыг бий болгоно гэж хэвлэл мэдээллийн судлаачид үздэг.*

»

зүйн халуун тогтоонд чанагдаж буй төлөөлөгчид дөнгөж хөл, хэлд орж буй Монголын хэвлэл мэдээллийг хоёр-гурван зуун жилийн түүхэн замналтай Өрнөдийн болон Америкийн сэтгүүл зүйтэй жишиж үл болно гэсэн хатуу байр суурьтай байдаг, түүнийгээ ч хамгаалсаар ирсэн.

2003 оны

12-р сарын 31-

ний байдлаар ХЗДХЯ-нд бүртгэлтэй нийт 1558 хэвлэл мэдээллийн хэрэгслээс 170 сонин, 60 сэтгүүл, 40 радио, 35 ТВ, 13 кабелийн ТВ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс гарын таван хуруунд багтахар цөөн нь сэтгүүл зүйн зарчмыг удирдлага болгохыг хичээдэг, харин дийлэнх олон нь дээрх нийтлэг зарчмын асуудлыг өөр өөрийн ойлголт, байр сууринаас тайлбарладаг. Үүнийг хэсэг сэтгүүлчдийн санаачилгаар 2003 онд бэлтгэсэн "Өрөөсгөл" нэртэй

телевизийн нэвтрүүлэгт оролцсон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, эрхлэгчдийн бодол санаа бэлхнээ гэрчилдэг. Тиймээс, сэтгүүл зүйн чанар чансаа, хэвлэл мэдээллийн өөрийн хариуцлагын асуудал хэвлэл мэдээллийн салбарын бодлогын үндэс болж чадаагүй ирсэн гэхэд хилсдэхгүй. Энэ үүднээс хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг өөрсдийнх нь эрхлэн гаргадаг хэрэгслээр дамжуулан нийтлэлч Б.Баабар мэдлэг боловсролгүйгээр нь дуудахдаа дуудаж, Монгол дахь АНУ-ын элчин сайд асан, ноён Жон Дингер мэргэжлийн төвшинд хэрхэн яаж ажиллах тухай сэтгүүл зүйн лекц унших нь тохиолдлын биш зүйл юм. Монголд ажиллаж буй гадны сэтгүүлч, мэргэжилтнүүд чөлөөт хэвлэл мэдээлэл хөгжөөд арав гаруй жил өнгөрөхөд агуулгын чанартай өөрчлөлт тэдгээрт хийгдэхгүй байгааг өнөө хэр гайхдаг.

**И**нгэж гайхах нь ч үндэстэй юм байна. Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагууд шинээр орж буй сэтгүүлчдэд тухайн байгууллагын дотоод журам ба сэтгүүлчийн баримтлах зарчим бүхий хоёр хавтас материалыг танилцуулсныхаа дараа хөдөлмөрийн гэрээ байгуулдаг юм байна. Шинээр ажилд орж буй сэтгүүлчийн хувьд бол боловсрол, мэргэжил эзэмших явцдаа сэтгүүл зүйн үндсэн зарчмуудын талаар хангалттай ойлголт авсан байдаг учир тэдгээрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдол бараг гардаггүй, нөгөө талаар, энэ зарчмаас гажвал сэтгүүлчдийн өөрсдийнх нь нэр хүндэд халтай гэдгийг ухамсарласан байдаг. Учир нь тэдний хэрэглэгчид бодитой, тэнцвэртэй мэдээлэл гэж ямар мэдээлэл болохыг мэддэг, түүнийгээ шаардаж чаддаг. Тухайлбал, Америкийн дунд сургуулиудын ахлах ангийн хөтөл-

бөрт сэтгүүл зүйн суурь ойлголтыг өгснөөр ирээдүйн уншигч, сонсогч, үзэгчээ бэлтгэхчидэг байна.

Энэ утгаар гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслийн бизнесийн амжилт болон сэтгүүл зүйн чанар, түүний дотор сэтгүүлчийн ур чадварыг тодорхойлох суурь шалгуур нь үндсэн зарчмуудыг баримталж, мөрддөг тууштай чанарт оршдог. Би-Би-Си (BBC)-гийн нэр хүнд, тэнд ажилладаг олон мянган сэтгүүлчийн мэргэжлийн төвшинг өнөөдөр яагаад хэвлэл мэдээллийн салбарын, сэтгүүл зүйн онол, практикийн аливаа асуудлын жишиг болгон авч үздэг нь үүнд оршино. Би-Би-Си-гийн танилцуулгад: "Дэлхийд хамгийн том бөгөөд итгэл хариуцлага хүлээсэн мэдээллийн хэрэгсэл" гэж өөрийн байгууллагаа бахархалтайгаар тодорхойлсон байдаг.

Тэгвэл ардчилсан сэтгүүл зүйн зарчмыг баримталдаг тогтвортой хэвлэл мэдээллийн хэрэгсэл өнөөдөр нийгэмд, **нэгдүгээрт**, өдөр тутмын үйл явдлын тухай тодорхой ойлголт өгөх агуулга бүхий үнэн, тодорхой, оюунлаг мэдээ, мэдээлэл; **хоёрдугаарт**, шүүмжлэл болон санал бодлоо солилцох боломж бололцоо; **гуравдугаарт**, нийгэм дэх бүлгүүдийн нэг нэгэндээ үзэл бодол, хандлагаа илэрхийлэх арга хэрэгсэл; **дөрөвдүгээрт**, нийгмийн үнэт зүйлс, зорилтуудыг тодруулах болон таниулан харуулах арга барил; **тавдугаарт**, өгч буй мэдээлэл, үзэл бодол, мэдрэмж зэргийн тухайн үеийн явц, өрнөлийг нийгмийн гишүүн бүрт хүргэх арга зам болдог жамтай.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б а а б а р Б. Чөлөөт хэвлэл ба түүний дайснууд. "Өдрийн сонин" 2000 оны 12-р сарын 16.

2. Б а т м а г н а й С. Мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах нь. "Сэтгүүлч" сэтгүүл. 2003. № 1.
3. Ц э р э н ж а в Д. Монголын сэтгүүл зүйн үнэн нүүр царай. "Аугаа үндэстэн" сонин. 2003 оны 8 сар.
4. Монголын хэвлэл мэдээллийн мониторинг 2003. Судалгааны эмхэтгэл.
5. 2003 оны 12 сарын 20-нд болсон "Монгол дахь хэвлэлийн эрх чөлөө өнөөдөр, маргааш" симпозиум дээр Жон Дингерийн хэлсэн үг.
6. The Journalist's Creed. Walter Williams.

7. 1997. Principles of American Journalism Don Ranly.

### Resume

The article focuses on the basic principles of good quality journalism. When these principles are being followed the journalists live up to good standards of journalism, but unfortunately these principles are not always being followed in Mongolia